

Агуулгын жагсаалт:

1.1. Үндэслэл.....	2
1.2. Байгаль орчны нөлөөлийн үнэлгээний шаардлагыг хангаж биелүүлсэн байдал.....	3
2. Гаалийн хяналтын бүс төслийн танилцуулга.....	4
2.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	4
2.2. Эрх зүйн үндэслэл.....	4
2.3. Үйл ажиллагааны зорилго.....	4
2.4. Гаалийн хяналтын талбайн бүтэц, зохион байгуулалт.....	4
2.5. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ.....	5
2.6. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ.....	5
3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ГАЗАР НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	11
3.1. Физик газарзүйн нөхцөл.....	11
3.2. Төслийн байршил.....	11
3.3. Нийгэм эдийн засгийн төлөв байдал.....	18
3.4. ДЭД БҮТЭЦ.....	19
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	21
4.1.....	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....22
4.2. 2026 оны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	23
4.3. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих төлөвлөгөө.....	26
4.4. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	26
4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	27
4.6. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	28
Хүснэгт 15. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	28
4.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	29
4.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	31
4.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	34
4.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	35

1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний батлагдсан аргазүй, аргачлал

1.1. Үндэслэл

БОМТ-г боловсруулахдаа 2019 оны 10-р сарын 29-ний өдөр шинэчлэгдэн батлагдсан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах тайлагнах журмыг удирдлага болгов.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах зардлыг тусгасан. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүний хэрэгжүүлэх арга зүй, хугацаа, давтамж, шаардагдах зардлыг тусгасан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг 12-р сарын 01-ний дотор Говьсүмбэр аймгийн Байгаль Орчны Газарт ирүүлж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж, тэднээр хэлэлцүүлэх ажлыг журмын дагуу зохион байгуулах шаардлагатай.

1.2. Байгаль орчны нөлөөлийн үнэлгээний шаардлагыг хангаж биелүүлсэн байдал

“УБ транс” ХХК нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутаг дэвсгэрт “Гаалийн хяналтын бүс” төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дараах зөвшөөрлүүд холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн захиргааны байгууллагуудаас олгогдсон байна.

➤ **“УБ ТРАНС ” ХХК**

Улсын бүртгэлийн дугаар: 9011100138

Регистрийн дугаар: 2572923

- Газар эзэмших эрхийн гэрчилгээ: Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн нутагт нэгж талбарын 4201002595 дугаартай 55494м² газар, нэгж талбарын 4201010787 дугаартай 12000 м² хэмжээтэй газрыг эзэмшин үйл ажиллагаа эрхэлдэг.
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний эхний тайланг 2013 онд батлуулсан;
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол хоёр дахь тайланг 2019 онд батлуулсан;
- 2024 оны 08 сарын 05-ны өдрийн 2024/ММ-161 дугаартай Ерөнхий үнэлгээний дүгнэлтийг БОУАӨЯ-ны Ерөнхий шинжээч 2024 оны 08 сарын 13-ны өдрийн 12/3725 дугаартай албан бичгээр баталгаажуулсан байна;
- Сүмбэр сумын Засаг даргын 2024 оны 05 сарын 15-ны өдрийн А/309 тоот дэмжсэн бичиг
- Сүмбэр сумын 1-р багийн иргэдийн хурлын 2024 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн 07 тоот тогтоол тэмдэглэл;

2. Гаалийн хяналтын бүс төслийн танилцуулга

2.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:

- Гаалийн хяналтын бүс

Төслийн дугаар:

- 2024/ММ-161

Төсөл хэрэгжүүлэгч:

- “УБ транс” ХХК, Улсын бүртгэлийн дугаар 9011100138,
Регистрийн дугаар 2572923 дотоодын 100 хувийн
хөрөнгө оруулалттай компани юм.

2.2. Эрх зүйн үндэслэл

- “Зөвшөөрөл олгох тухай” Гаалийн Ерөнхий Газрын
даргын 2014 оны 11-р сарын 13-ны өдрийн А/20-р
тушаалаар батлагдсан” нээлттэй гаалийн баталгаат
агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг гурван
жилийн хугацаатайгаар гаалийн хяналтын талбай
ажиллуулах зөвшөөрөл авсан байна.

2.3. Үйл ажиллагааны зорилго

- Төвлөрсөн нэг дор үйлчилгээг төгс хүргэхэд “УБ
транс” ХХК зорилгоо болгон ажилладаг.

2.4. Гаалийн хяналтын талбайн бүтэц, зохион байгуулалт

“УБ транс” ХХК нь Говьсүмбэр аймгийн Чойрт Монгол улсын стандартад нийцсэн,
“Ачааны терминал”-ийг 2010 онд барьж ашиглалтанд оруулжээ. 2014 оны 3-р улирлаас нийт
5.5 га, 2022 онд 1.2 га-г нэмж үйл ажиллагаа эрхэлж Гаалийн Хяналтын бүс бүрэн ашиглалтанд
орсон одоогоор 6.75 га талбайд үйл ажиллагаа явуулж өргөжсөн.



2.5. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ:

- 3 тоннын авто-погрушка
- 5 ш хяналтын камер, 10 ш гэрлийн шон
- 1 ш 180° хяналтын камер
- 1 ш 450 Ваттийн проектор бүхий 25 метрийн өндөр цамхаг
- КС32 маркийн гүүрэн кран
- ВТВ-Д 150 тоннын динамик вагон пүү
- SC-150 тоннын авто пүү
- 3м³ -ын ковш

2.6. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ:

Гаалийн баталгаат агуулах нь 66*24 метрийн харьцаатай 1584 м² бүхий багтаамжтай.







Зураг 1.Нурмаг ачаа буулгах талбай



Зураг 2.Нэгж талбарт салаа төмөр зам орох хаалганы хэсэг



Зураг 3.Хоёр салаа төмөр зам





Зураг 4.Авто пүү


3.ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ГАЗАР НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

3.1. Физик газарзүйн нөхцөл:

Говьсүмбэр аймаг нь Монгол орны физик газарзүйн хувьд “Говь хээрийн талархаг их муж”-ын Халхын дундад ба Дарьгангын талархаг дэд мужийн Ухаа гүвээт Халхын дундад талын дэд мужид хамаарна.


3.2. Төслийн байршил

Гаалийн хяналтын талбай нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн нутаг дэвсгэрт Сүмбэр сумын зүүн урд талд, байрзүйн L-49-49 талбайд байрлаж далайн түвшингээс дээш 1002 метрийн өндөрт байрлаж байна.Бүс бүслүүрийн хувьд хуурай хээрийн экосистемтэй хээрийн бүсэд багтана (Газар зүйн атлас, 58-59 хууд. 2004) .



Зураг 5.Төслийн талбайн байршлын тойм зураг





Нэгж талбарын дугаар, газрын мэдээлэл, байршил-1

“УБ транс” ХХК нь Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 31-ны өдрийн А/317 тоот шийдвэрээр олгогдсон нэгж талбарын 4201002595 дугаартай 55494 м/кв газарт **“ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС”** төслийг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 1.Нэгж талбарын 4201002595 дугаартай газрын эргэлтийн цэг

д/д	Уртраг			Өргөрөг		
1	108	21	10.08	46	20	34.99
2	108	21	16.25	46	20	37.95
3	108	21	26.04	46	20	42.72
4	108	21	27.96	46	20	43.64
5	108	21	28.1	46	20	43.67
6	108	21	28.02	46	20	43.22
7	108	21	28	46	20	42.86
8	108	21	27.58	46	20	41.84
9	108	21	26.73	46	20	38.1
10	108	21	13.38	46	20	31.67
11	108	21	11.87	46	20	30.95
12	108	21	8.62	46	20	34.34

➤ Нэгж талбарын дугаар, газрын мэдээлэл, байршил-2

“УБ транс” ХХК нь Сүмбэр сумын Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/234 тоот шийдвэрээр олгогдсон нэгж талбарын 4201010787 дугаартай 12000 м/кв газарт **“ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС”** төслийг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 2.Нэгж талбарын 0000383454 дугаартай газрын эргэлтийн цэг

д/д	Уртраг			Өргөрөг		
1	108	21	7.91	46	20	29.011
2	108	21	5.999	46	20	28.091
3	108	21	3.407	46	20	31.979

4	108	21	5.705	46	20	33.022
5	108	21	6.397	46	20	31.887
6	108	21	6.742	46	20	31.285
7	108	21	9.257	46	20	32.28
8	108	21	8.886	46	20	32.975
9	108	21	8.072	46	20	34.095
10	108	21	8.632	46	20	34.349
11	108	21	11.872	46	20	30.975
12	108	21	10.561	46	20	30.354
13	108	21	9.868	46	20	31.499
14	108	21	7.194	46	20	30.363



Умард-Говийн гүвээт-Халхын дундад талын сав газар. Говьсүмбэр аймгийн харъяалагдах Умард говийн усны сав газар нь 8 аймаг, 59 сум, Нийслэлийн Багахангай дүүргийн газар нутгийг хамарсан нийт 180404.2 км² талбай бүхий говь, хээрийн бүсүүдийг хамарсан өргөн уудам нутаг юм. Далайн төвшнөөс дээш дунджаар 1267 метр өргөгдсөн өргөн уудам тал нутаг юм. Баруунаас зүүн хүртэл 858 км ба хойноос урагш 424 км бөгөөд нийт хилийн цэсийн урт нь 2700 км. Умард говийн усны сав газарт Говьсүмбэр аймгийн 70.9 хувь нь хамрагдаж байна. Үүнээс Сүмбэр сумын нийт талбай нь 3753,47 км², Умард говийн усны сав газарт хамрагдах талбай 2142,72 км² буюу 57,1% газар нутгийг эзлэж байна.

Уур амьсгал. Цаг уурын нөхцлийг тодорхойлоход Ус Цаг Уур орчны шинжилгээний газрын олон жилийн ажиглалтын мэдээг ашигласан болно. Говьсүмбэр аймаг нь далайн түвшнээс дээш 1000-1200 метрийн өндөрт оршдог говь, тал хээр хосолсон эх газрын эрс тэс уур амьсгалтай нутаг юм. Тус аймагт жилд унах тунадасны хэмжээ говийн бүсийнхээс илүү

/дунджаар 200-250 мм/ бөгөөд температурын ялгаа зундаа +37⁰, өвөл -37⁰ градус байдаг. Говь, хээрийн бүс нутгаар 7 дугаар сарын дундаж температур 20 хэм-ээс, 23-25 хэмийн хооронд хэлбэлзэж үнэмлэхүй их нь 40 хэмээс давж гарна. Жилд унах хур тунадасны 85-90 хувь нь 4-10

дугаар саруудад ногдож байгаагаас үүний 50-60 хувь 7,8 дугаар сард орно. Монгол орны уулархаг нутагт 60-70 хоног бороотой байхад говь, хээрийн бүсэд 30-50 хоног хүрэхгүй өдөр зарим жил 10-аадхан өдөр зарим жил үүнээс цөөхөн өдөр бороо ордог. Олон жилийн дунджаар говийн бүсэд 100 мм, хээрийн бүсэд 100-250 мм тунадас ордог байна.

Салхины хурд. Умард говийн усны сав газарт жилд болдог шороон шуурганы 60 орчим хувь нь 3,4,5,12 дугаар сард ажиглагддаг. Үүнээс хамгийн их салхитай байх сар нь 5-р сар байдаг байна. Энэ үеэр салхины хурд 18-24 м/с хүрч, шороон болон цасан шуурга шуурч өнгөн хөрс салхинд хийсч, ургамлын үндэс, шороо элсний хуримтлал үүсдэг байна. Олон жилийн ажиглалтын мэдээнээс үзэхэд салхины хамгийн их хурд 34 м/с хүрнэ. 15 м/с буюу түүнээс хүчтэй салхитай өдрийн тоо жилд дунджаар 16-30 байна. (УЦУОШГ 2025)

Цасан бүрхүүл. Цасны зузаан 2-3 см хамгийн ихдээ 14 см хүрч байсан. Цасан бүрхүүлтэй байх хугацаа 120-130 байсан бол сүүлийн 10 жилийн дунджаар 110-115 хоног болж буурсан. Цэлмэг өдрийн тоо жилд 230-260 хоног, нарны гийгүүлэх хугацаа 2300-2600 цаг байна.

Геологи. Умард говийн ихэнх нутаг дундад төрмөлийн эринд хурдас хуримтлалын муж байсан ба гуравдагч галавын сүүл, дөрөвдөгч галавын эхний уул тогтох хөдөлгөөнөөр төдийлөн өргөгдөөгүй тул дундад ба шинэ төрмөлийн эриний хурдас багагүй тархсан байна. Говь нутгийн гадаргын онцлог хэлбэр бол цав зоо гэж нэрлэгдэх эртний тунамал хурдсын илэрцүүд юм. Энэ нь эртний нуур, далайн тунамал зузаан хурдас уруйн усанд болон нар, салхинд идэгдэж элэгдсэнээс гадарга нь толгодлог, гүвээрхэг, зарим газар үлдэц тавцан байдалтай болж хоцорсон нь түгээмэл юм. Энэ хурдсын нэг онцлог бол цэрдийн галавын болон палеогений галавын аварга хөхтөн амьтдын чулуужсан яс элбэг агуулсан байдагт оршино¹. Говьсүмбэр аймаг нь нүүрс, тоосгоны шавар, эрдэс будаг, хайлуур жонш, шохойн болон бал чулууны байгалийн баялаг нөөцтэй өгөөмөр баян нутаг юм.


Гадаргын усны нөөц. Говьсүмбэр аймаг нь Төв азийн гадагшаа урсгалгүй ай савын Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт хамаарна. Тус сав газар нь усны нөөцийн ангилалаар газрын доорх усны нөөцтэй ангилалд хамаардаг.

Гидрогеологийн нөхцөл; Дөрвөлжин овоот, Чойрын газрын Доорх усны ай сав нь ус зүйн хувьд газар доорх усны нөөц зонхилсон “Умард говийн гүвээт-Халхын дундад тал” сав газарт хамаарна.

Газар хөлдөлтийн бүс: Умард говийн сав газрын хувьд олон жилийн цэвдэг чулуулаг тохиолдлын тархалттай бүслүүр болон улирлын цэвдэг чулуулаг үүсдэг бүслүүр нутагт хамаарна. Говьсүмбэр аймаг нь улирлын хөлдөлтийн бүсэд хамаарч байна.

Хөрсөн бүрхэвч. Төслийн талбайн хөрсөн бүрхэвч Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн Хээрийн хүрэн хөрсний бүс, Хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүс, Бор өндөр-Уул баянгийн тойрогт хамаарагдана (Доржготов Д., УБ 1984, 1994)

¹ Умард говийн ухаа гүвээт сав газрын тайлан, хууд 18



Зураг 6. Монгол орны Хөрс-газарзүйн мужлалын зураг

Судалгааны үр дүн: Судалгаанд хамрагдсан Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн нутагт хэрэгжиж буй Гаалийн хяналтын бүс төслийн талбай нь хөрсний газарзүйн мужлалтаар хөрс-био уур амьсгалын Хангайн их мужийн Хээрийн хүрэн хөрсний бүс, Хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүс, Бор өндөр-Уул баянгийн тойрогт багтах (Доржготов Д., УБ 1984, 1994) бөгөөд судалгааны талбай орчим нь далайн түвшнээс дээш 1002-1020 метр өндөрт байрлах ба хуурай хээрийн жинхэнэ хүрэн хөрс тархаж тогтворшсон байна.



Ургамлан нөмрөг: Монгол орны ботаник-газарзүйн мужлалаар Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Гаалийн хяналтын бүс” төсөл нь Дундад Халхын хээрийн тойрогт хамаарах ба уг сумын нутаг дэвсгэрт хуурай хээрийн болон өмнө хагасдаа говийн ургамал ургана.



Зураг 7. Ургамал газарзүйн 16-н тойрог

Судалгааны арга зүй;

Ургамалжил, бэлчээрийн ургамлын ангилаа бүртгэл, түүний тархацыг тодорхойлох зорилгоор ургамал бүлгэмдэл түүнийг бүрдүүлж буй ургамлын зүйлийн баялгийн жагсаалтыг гаргах зорилгоор бүлгэмдэл тус бүрт тухайн бүлгэмдлийг төлөөлөх талбайг сонгон талбай тус бүрт 5 давталттайгаар ургамалжилзүйн бичиглэл хийсэн.

Зүйлийн баялаг: Ургамалжлын зүйлийн баялагийг тодорхойлохдоо нийт талбайн хэмжээнд тархсан ургамлын баялагийг флорын баялаг тодорхойлох аргаар бүртгэж, зүйлийн латин, монгол нэрийг (Грубов, 1982) бүтээлд зааснаар нэрлэв.

Тусгаг бүрхэц: Бүлгэмдэл тус бүрийн ургамлын арви-бүрхэцийг тодорхойлохдоо Браун-Бланке-гийн аргаар (Раменский, 1938) 1м² хэмжээт торыг ашиглан бүлгэмдлийн хэмжээнд сонгож авсан талбай бүрт 5 давталттайгаар арви- бүрхэцийг тодорхойлсон.

Ургамалжлын зүйлийн бүрэлдэхүүн

Судалгааны талбайн нь хуурай хээрийн бэлчээр бөгөөд 2 бүлгэмдэлд 15 овгийн 37 төрлийн нийт 47 зүйл ургамал бүртгэгдсэн. Энэхүү ургамал нь амьдралын хэлбэрийн хувьд

❖ сөөг	2,
❖ сөөгөнцөрлөг	2,
❖ сөөгөнцөр	1,
❖ олон наст өвс	26,
❖ ганц ба хоёр наст	16 зүйл ургамал тус тус тэмдэглэгдэв.

Ургамлын амьдралын хэлбэрээр нь эзлэж байгаа хувиар сөөг 4%, сөөгөнцөрлөг 4%, сөөгөнцөр 2%, олон наст өвс 56%, ганц ба хоёр наст 34% байна.

Хүснэгт 3. Судалгаа хийсэн талбайн ургамлын зүйлийн жагсаалт

Д/д	Зүйлийн Латин нэр	Зүйлийн Монгол нэр	Арви	Тусгаг бүрхэц %	Амин хэлбэр
1. Poaceae-Биелэгтэн					
1	<i>Achnatherum splendens</i>	гялгар Дэрс	Cop1	3	олон наст
2	<i>Agropyron cristatum</i>	саман Ерхөг	Sp	1	олон наст
3	<i>Aristida Heymannii</i>	нохой Бөөдий	Sp	1	нэг наст
4	<i>Bromus inermis</i>	соргүй Согоовор	Cop1	5	олон наст
5	<i>Chloris virgata</i>	саваан Булган сүүл	Cop2	4	нэг наст
6	<i>Cleistogenes songorica</i>	зүүнгарын Хазаар өвс	Sp	1	олон наст
7	<i>Elymus chinensis</i>	хиаг Түнгэ	Sp	2	олон наст
8	<i>Elymus dahuricus</i>	дагуур Өлөнгө	Sp	2	олон наст
9	<i>Enneapogon borealis</i>	умардын Оготны сүүл	Sp	2	нэг наст
10	<i>Eragrostis minor</i>	бага Хургалж	Sp	1	нэг наст
11	<i>Setaria viridis</i>	ногоон Хоног будаа	Sp	1	нэг наст
12	<i>Stipa krylovii</i>	крыловын Хялгана	Sp	1	олон наст
13	<i>Stipa gobica</i>	говийн Хялгана	Sp	1	олон наст
2. Fabaceae-Цандуйтан					
14	<i>Caragana microphylla</i>	Бяцхан навчит Харгана	Sol	+	сөөг
15	<i>Caragana stenophylla</i>	нарийн Харгана	Sp	1	сөөг
16	<i>Medicago falcata L.</i>	Шар царгас	Sp	1	олон наст
3. Cyperaceae- Улалжтан					
17	<i>Carex pediformis</i>	Зогдор улалж	Sp	2	олон наст
4. Liliaceae-Сараанатан					
18	<i>Allium mongolicum</i>	хөмөл Сонгино	Sp	1	олон наст
19	<i>Allium odorum</i>	анхил Сонгино	Sp	1	олон наст
20	<i>Asparagus gobicus</i>	говийн Хэрээн нүд	Sol	+	олон наст
5. Asteraceae-Гол гэсэртэн					
21	<i>Scorzonera divaircata</i>	дэрэвгэр Хависгана	Sp	2	олон наст
22	<i>Artemisia frigida</i>	агь Шарилж	Sp	1	сөөгөнцөрлөг
23	<i>Artemisia pectinata</i>	үхэр шүлхий Шарилж	Sp	3	хоёр наст
24	<i>Artemisia macrocephala</i>	царвант Шарилж	Sp	2	нэг наст
25	<i>Artemisia scoparia</i>	Ямаан шарилж	Sp	1	нэг наст
26	<i>Lactuca tatarica</i>	татаар Зираа	Sol	+	олон наст
6. Brassicaceae-Тоонолжин цэцэгтэн					
27	<i>Lepidium latifolium L</i>	зүрхэн навчит Цангуу	Sol	+	олон наст
28	<i>Ptilotrichum canescens</i>	бууралдуу Янгиц	Sol	+	сөөгөнцөрлөг
7. Convolvulaceae-Сэдэргэнтэн					
29	<i>Convolvulus ammanii</i>	амманы Сэдэргэнэ	Sp	1	олон наст
8. Iridaceae-Цахилдагтан					
30	<i>Iris tenuifolia</i>	цулбуур Цахилдаг	Sol	+	олон наст
9. Rosaceae-Сарнайтан					
31	<i>Potentilla anserina L.</i>	галуун Гичгэнэ	Sol	+	олон наст
32	<i>Potentilla bifurca L.</i>	имт Гичгэнэ	Sp	+	олон наст
10. Chenopodiaceae- Луультан					
33	<i>Bassia dasyphylla</i>	үслиг Манан-хамхаг	Sp	1	нэг наст
34	<i>Corispermum mongolicum</i>	монгол Хамхуул	Sp	1	нэг наст
35	<i>Salsola collina</i>	толгодын Бударгана	Sp	1	нэг наст
36	<i>Kochia prostrata</i>	дэлхээ Тогторгоно	Sp	1	сөөгөнцөр
37	<i>Chenopodium aristatum</i>	Сортой лууль	Sp	1	нэг наст

38	<i>Chenopodium acuminatum</i>	шоргор Лууль	Sp	1	нэг наст
39	<i>Chenopodium album</i>	цагаан Лууль	Sp	1	нэг наст
40	<i>Dracocephalum foetidum</i>	Үмхий шимэлдэг	Sp	1	нэг наст
41	<i>Halogeton glomeratus</i>	баг Хуг хамхаг	Sp	2	нэг наст
11.Asclepiadaceae-Ерөндгөнийн овог					
42	<i>Vincetoxicum sibiricum</i>	сибирь Ерөндгөнө	Sol	+	олон наст
43	<i>Heteropappus hispidus</i>	арзгар Согоолж	Sp	+	олон наст
12.Urticaceae- Халгайн Овог					
44	<i>Urtica cannabina L.</i>	олслиг Халгай	Sp	1	олон наст
13.Plantaginaceae-Таван салааны овог					
45	<i>Plantago depressa</i>	Навтгар таван салаа	Sp	+	олон наст
14.Rutaceae-Сүлүүгийн овог					
46	<i>Haplophyllum dahuricum</i>	дагуур Хүж өвс	Sp	+	олон наст
15.Labiatae-Уруул цэцэгтэн					
47	<i>Leuzea uniflora (L.)</i>	Өнчин хонгорцгоно	Sp	0.5	олон наст
Нийт тусгаг бүрхэц, 52.5					

3.3. Нийгэм эдийн засгийн төлөв байдал



Говьсүмбэр аймаг нь 5.5 хавтгай дөрвөлжин км газар нутагтай. Засаг захиргааны нэгжийн хувьд 3 сум 10 багтай бөгөөд өөрийн аймгийн иргэд, зэргэлдээ сумын иргэд нийт 20 гаруй мянган хүнд төрийн үйлчилгээ үзүүлдэг. 2023 оны статистикийн гаргасан мэдээгээр хүн амын 1 км²-д ногдох хүн 3.3, нийт хүн ам 18.0 мянган хүн, үүнээс хотод суурьшсан 3.2 мянган хүн, хөдөөд 2.2 мянган хүн амьдардаг.

Хүснэгт 4. Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтрал

Аймгийн нэр	Нутаг дэвсгэрийн хэмжээ, мянган км ²	ХҮН АМЫН НЯГТРАЛ /1 км ² -д ногдох хүн/				
		2019	2020	2021	2022	2023
Говьсүмбэр	5.5	3.3	3.3	3.3	3.3	3.3

Хүснэгт 5. Говьсүмбэр аймгийн хүн ам, мянган хүн

Аймгийн нэр	ХҮН АМ /Мянган хүн/				
	2019	2020	2021	2022	2023
Говьсүмбэр	17.9	18.0	18.1	18.0	18.0

Хүснэгт 6. Говьсүмбэрийн өрхийн тоо

Аймгийн нэр	ӨРХ /Мянган өрх/									
	2019		2020		2021		2022		2023	
	хот	хөдөө	хот	хөдөө	хот	хөдөө	хот	хөдөө	хот	хөдөө
Говьсүмбэр	3.0	2.0	3.0	2.1	3.1	2.2	3.1	2.2	3.2	2.2

Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид: Говьсүмбэр аймгийн хэмжээнд жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч хуулийн этгээд 2022 оны байдлаар 179 байна.

Хүснэгт 7. Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч хуулийн этгээд

Аймгийн нэр	Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч хуулийн этгээд			
	2019	2020	2021	2022
Говьсүмбэр	183	165	167	179

Мал аж ахуй: Малын тоо 2023 онд 64.7 сая толгойд хүрч, адуу 4.8 сая, үхэр 5.4 сая, тэмээ 473.9 мянга, хонь 29.4 сая, ямаа 24.6 сая толгой боллоо. Малын тоог 2019 онтой харьцуулахад нийт малын тоо 6.3 сая буюу 8.9 хувь, хонь 2.9 сая буюу 8.9 хувь, ямаа 4.6 сая буюу 15.9 хувиар тус тус буурч, адуу 614.9 мянга буюу 14.6 хувь, үхэр 597.6 мянга буюу 12.6 хувь, тэмээ 1.5 мянга

буюу 0.3 хувиар тус тус өссөн байна. Малын тоо өмнөх оноос 6.4 сая буюу 9.1 хувиар буурсан бөгөөд төрлөөр авч үзэхэд, хонь 3.3 сая (10.2%), ямаа 3.0 сая (10.7%), үхэр 162.1 мянга (2.9%)-аар тус тус буурч, адуу 8.6 мянга (0.2%), тэмээ 3.4 мянга (0.7%)-аар тус тус өссөн байна.

Тэжээвэр амьтдаас гахайн тоо 2023 онд 25.6 мянга болж, 2019 оноос 4.7 мянгаар, шувууны тоо 1.8 саяд хүрч, 901.2 мянгаар тус тус өссөн байна. Өмнөх онтой харьцуулахад гахай

9.2 мянга (26.3%)-аар буурч, шувуу 284.3 мянга (18.8%)-аар өссөн байна.

Хүснэгт 8. Говьсүмбэр аймгийн малын тоо

Аймгийн нэр	Малын тоо /Мянган тоо/				
	2019	2020	2021	2022	2023
Говьсүмбэр	452	451	432.2	464.3	450.1

Хүснэгт 9. Говьсүмбэр аймгийн малчин өрх

Аймгийн нэр	Малчин өрх/ тоо/				
	2019	2020	2021	2022	2023
Говьсүмбэр	699	761	802	798	778

Газар тариалан: Монгол улсын хэмжээнд 2023 онд үр тариа 470.3 мянган тонн, таримал тэжээл 258.2 мянган тонн, хүнсний ногоо 208.4 мянган тонн, төмс 179.4 мянган тонныг тус тус хураан авчээ. Хураасан төмс өмнөх оноос 34.6 (16.2%) мянган тонн, хураасан жимс, жимсгэнэ 0.3 (10.5) мянган тонноор тус тус буурч, харин хураасан таримал тэжээл 87.0 (50.8%) мянган тонноор, хураасан хүнсний ногоо 59.5 (40.0%) мянган тонноор, хураасан үр тариа 41.7 (9.7%) мянган тонноор, хураасан техникийн ургамал 6.1 (12.5%) мянган тонноор тус тус өссөн байна. 2019 онтой харьцуулахад хураан авсан төмс 12.9 (6.7%) мянган тонноор буурч, харин таримал тэжээл

137.1 (2.1 дахин) мянган тонноор, хүнсний ногоо 108.8 (2.1 дахин) мянган тонноор, үр тариа 37.0 (8.5%) мянган тонноор, техникийн ургамал 21.3 (62.7%) мянган тонноор, жимс, жимсгэнэ 0.5 (29.2) мянган тонноор тус тус өссөн байна.

Хүснэгт 10. Говьсүмбэр аймгийн тариалалт хийсэн талбай

Аймгийн нэр	Тариалсан талбай /га/				
	2019	2020	2021	2022	2023
Говьсүмбэр	50.1	49.5	60.7	95.7	74.3

Сүмбэр сум: Сүмбэр сум нь засаг захиргааны 6 багтай, 1, 2, 3 дугаар баг нь сумын төвд, 4, 5, 6 дугаар баг нь хөдөөд байдаг. Сүмбэр сум нь 2023 оны байдлаар 13260 хүн амтай үүний 6553 эрэгтэй, 6707 эмэгтэй. Төсөл хэрэгжиж буй 1-р багт 2764 хүн ам оршин суудагаас эрэгтэй 1376, эмэгтэй 1388, 849 өрх байгаагаас бүгд аймгийн төвд оршин суудаг. Сүмбэр сум нь 376819 га газар нутагтай, 1 км.кв-д ногдох хүн амын нягтрал 3.5 байна.

3.4. ДЭД БҮТЭЦ:

Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум нь далайн түвшингээс дээш 1000-1200 метр өндөрт өргөгдсөн, 553482 га талбай нутаг дэвсгэртэй, олон улсын А1 авто зам дайран өнгөрдөг, дэд бүтэц хөгжсөн төмөр замаар урд болон хойд хөрштэй харилцах боломжтой зүүн өмнөд бүсийн төв юм. Умард говийн сав газрын нутаг дэвсгэрээр Мянганы замын босоо тэнхлэгийн хатуу хучилттай авто зам, Бээжин-Улаанбаатар-Москва чиглэлийн ТрансСибирийн төмөр зам, Улаанбаатар-Дундговь-Өмнөговь чиглэлийн хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг.

АВТО ЗАМ:

“УБ транс” ХХК-ийн “Гаалийн хяналтын бүс” төсөл нь Сүмбэр сумын төв Чойрт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос 230 км хар замаар, сумын төвөөс баруун урд зүгт 1.8 км

шороон замаар яваад төслийн талбайд хүрнэ. Олон Улсын А1 авто зам, төмөр зам дайран өнгөрдөг.

ДУЛААН ХАНГАМЖ:

Барилгыг өвлийн улиралд дулаанаар хангах асуудлыг цахилгаан халаагуураар шийдвэрлэжээ. Энэ нь утаа гарахгүй агаарын бохирдол үүсгэхгүй сайн талтай. Цахилгаан хангамжийг Говьсүмбэр аймгийн төвийн эх үүсвэрээс хангадаг.

ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН ЭХ ҮҮСВЭР:

Төсөл хэрэгжүүлэгч цахилгааны эх үүсвэрийг бүрэн шийдсэн.

Зураг 8. Цахилгаан хангамж



4.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

Гол зорилтууд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;
- Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р хороонд байрлах “УБ транс” ХХК “Гаалийн хяналтын бүс” төслийн 2026 оны БОМТ-г БОАЖЯ-ийн сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлан боловсруулсан болно.

- Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор энэхүү журмын 3-р хавсралтын дагуу гаргаж, харьяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.
- Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг аймаг, нийслэлийн томилсон ажлын хэсэг газар дээр нь хянаж үнэлсэн нэгдсэн дүн 90 онооноос дээш гүйцэтгэлтэй байвал дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- Монгол улсын “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь заалтын дагуу төсөл хэрэгжүүлэгч жил бүрийн 12 дугаар сард багтаан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагаар батлуулж байх шаардлагатай;

Хүснэгт 11. Байгаль орчныг хамгаалах 2026 оны төлөвлөгөөний нэгтгэл

№	Арга хэмжээ	Нийт дүн, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	8,800,000 төгрөг
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	500,000 төгрөг
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	300,000 төгрөг
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,660,000 төгрөг
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,175,000 төгрөг
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	11,800,000 төгрөг
Зарцуулах зардал, төг		24,235,000 төгрөг

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

“УБ транс” ХХК-ийн “Гаалийн хяналтын бүс” төслийн үйл ажиллагааны явцад 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль орчинд үүсэх сөрөг нөлөөллийг тухай бүрт бууруулж ажиллахаар төлөвлөж байна. Үүнд:

- Төслийн талбай дээрх ногоон байгууламжийн талбайг услах, арчилж ургуулах;
- Ахуйн хог хаягдлуудыг ангилан ялгаж, хоёрдогч түүхий эдийг дахин боловсруулдаг компанид нийлүүлэхээр хүргүүлэх;
- Агаарын тоосжилт, салхины хүчийг бууруулах торон хашаа барих;
- Усны хэрэглээнд хяналт тавьж үр ашигтай зарцуулалт бий болгож, усны хэрэглээг багасгах талаар анхаарч ажиллах;
- Гаалийн хяналтын үүд угтах хэсгийн автомашины зогсоолыг хатуу хучилттай болгож хөрс хамгаалах (бетондох);
- Хөрсийг хамгаалж бетонжуулахаар бэлтгэл ажлыг хийж 3000 м² газрыг тэгшлэх;
- Үйл ажиллагааны явцад учирч болзошгүй эрсдэл аюулаас бүрэн сэргийлж ажиллах, холбоотой сургалтыг тогтмол зохион байгуулах;
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заасан хөрс, гүний худгийн усны шинжилгээг Нарт шуун ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораториудад шинжлүүлэх;
- Орчны цэвэрлэгээг тогтмол зохион байгуулсан гэх мэт ажлуудыг 2026 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.

**Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн нутагт байрлах
“УБ транс” ХХК-ийн “Гаалийн хяналтын бүс” төслийн 2026 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөө**

4.2.2026 оны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 12.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян.төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
2	Талбайн тоосжилтыг бууруулах	Салхинаас хамгаалах хашааг засварлан тохижуулах, төмөр торон хашаа / 6-10 м / хойд талаар барих	Хашааны хойд талаар	Батлагдсан зураг төслийн дагуу хийж гүйцэтгэх	2,000.0	**	2,000.0	2026 он	
4	Авто тээврийн хэрэгслээс тоосжилт, хорт хий ялгарах	Шаардлагагүй тохиолдолд тээврийн хэрэгслийг унтрааж байх	Төслийн талбайд	ТОГТМОЛ	**	**	Үйл ажиллагааны зардал	2026 он	
5	Үйл ажиллагааны горим, технологийн дараалал алдагдсанаас осол	-Гаалийн хяналтын талбайд орох гарах, гарц замыг тохижуулан тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Төслийн талбайд	ТОГТМОЛ	**	**	Үйл ажиллагааны зардал	2026 он	
6	эрсдэл гарах, байгаль орчин бохирдох	-Аюултай болон бусад хог хаягдлыг түр хадгалах цэгт хаягдал материал, түүхий эдийг удаан байлгахгүй байхад анхаарч, дахин боловсруулах үйлдвэрт нэн даруй хүргэх	Төслийн талбайд	ТОГТМОЛ	**	**	Үйл ажиллагааны зардал	2026 он	
		-Технологийн доголдлын үед гарах ослоос урьдчилан сэргийлж, ослын үед авах арга хэмжээнүүдийг нөлөөллийн хэлбэр бүрээр үйл ажиллагааны туршид хэрэгжүүлэх	Төслийн талбайд	ТОГТМОЛ	**	**	Үйл ажиллагааны зардал	2026 он	
7	Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Ажиллагсдыг дуу шуугианаас хамгаалах чихэвч зүүлгэх, маск зэрэг хувцас хэрэгсэлээр хангах	Ажилтан бүрийг хамруулах	ТОГТМОЛ	**	**	Үйл ажиллагааны зардал	2026 он	

**Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн нутагт байрлах
“УБ транс” ХХК-ийн “Гаалийн хяналтын бүс” төслийн 2026 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөө**

8	Агаарын чанарын өөрчлөлтийг хянах	Агаарын чанарын мониторинг судаалгааг хийх	Төслийн талбай болон ойр орчимд	Тогтсон хугацаанд	**	**	ОХШХ-т тусгав	2026 он	
Дүн						2,000.0 мян.төгрөг			
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
9	Ажилчдын унд ахуйд хэрэглэх усны нөөцийг хэмнэлттэй ашиглах	Худгаас хангах ажилчдын ахуйн болон цайны газрын усны оролт болон гаралт дээр тоолуур (хаягдал ус) суурилуулах.	Худгийн насосны гаралт дээр суурилуулна.	2026 онд	**	**	**	2026 он	“Усны тухай хууль” “Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль”
10	Төлбөр хураамж	Усны нөөц ашигласны төлбөр төлөх	Тоолуурын заалтын дагуу ус ашигласны төлбөр төлнө.	2026 онд	**	**	**	2026 он	“Ус ашиглуулах дүгнэлт гаргуулах үйлчилгээний хөлс” “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”
13	Усыг хэмнэх	Ногоон байгууламжийг усалгааг хийхдээ хаягдал пластик сав ашиглан дуслын услалтын систем ашиглах	Усны нөөцийг хэмнэж ногоон байгууламж услах	Тогтмол	Дотоод зардалд тусгах	**	***	2026 он	“Ус ашиглалт хэрэглээг тоолууржуулах журам”, “Ундны ус.Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавигдах хяналт MNS 0900:2018”
14	Борооны ус ашиглах	Ногоон байгууламжид борооны усыг ашиглан усалгаажуулах	Усны нөөцийг хэмнэж ногоон байгууламж услах	Тогтмол	Дотоод зардалд тусгах	**	***	2026 он	-MNS 6148:2010 “Усны чанар. Газар доорх усыг бохирдуулагч бодисын ЗДХ”
16	Хаягдал бохир усны орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл	Цэгийг бетон, төмөр бетон болон бусад ус үл нэвчих материалаар доторлоно	Цэгийг бетон, төмөр бетон болон бусад ус үл нэвчих материалаар доторлох	Тогтмол хянах	200.0	**	200.0	2026 он	“Усны чанар. Газар доорх усыг бохирдуулагч бодисын ЗДХ”
		“УСДҮ” ОНӨААТҮГ -тай хийсэн “Бохир ус татан зайлуулах гэрээ”-ний хэрэгжилтийг хангах. Шингэн хог хаягдал цуглуулах септик танкинд хяналт шалгалтыг тогтмол хийж, хальж асгарахаас сэргийлэх;	Хөрс бохирдох	Тогтмол хяналт тавих	**	**	**	2026 он	“MNS 4943 - 2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага”
17		Ус ашиглагч нь цэгийн эзлэхүүний 70-80 хувь дүүрсэн үед суллаж, цэг болон цэгийн орчинд халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр халдваргүйжүүлэлтийг хийлгэнэ.	Бохир усыг зөөвөрлөж зайлуулах, орчны ариун цэврийг хангах	Тухай бүр	300.0	**	300.0	2026 он	“Ус ашиглалт хэрэглээг тоолууржуулах журам”,
Дүн						500.0 мян.төг			

**Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн нутагт байрлах
“УБ транс” ХХК-ийн “Гаалийн хяналтын бүс” төслийн 2026 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөө**

Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
20	Хөрс элэгдэл эвдрэлд орж гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Барилга байгууламжийн гадна талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчныг цэвэр байлгах	Төслийн талбай		Үйл ажиллагааны зардал	**	**	2026 он	MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 3297:2019, Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх
22	Нурмаг ачааны тавцанг бетонжуулах	Нурмаг ачааны 3000 м² талбайг бетонжуулах	3000 м² жонш буулгадаг талбайг хатуу хучилттай болгох	3000 м²	3,000.0	3000 м²	6,000.0	2026 он	
23	Хөрсний бохирдох	Хөрсний бохирдол, чанарыг хянах мониторинг судалгааг хийх	Төслийн талбайн хөрс	Тогтсон хугацаанд	ОХШХ-т тусгасан	**	**	2026 он	
24	Хог хаягдлаар бохирдох	Төслөөс үүсэх аюултай болон энгийн хог хаягдлыг сумаас зөвшөөрөгдсөн цэгт хаяж зайлуулах	Төслийн талбайд	Тухай бүр	Үйл ажиллагааны зардал	**	**	2026 он	
Дүн						6,000.0 мян.төг			
Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
25	Ургамал	Үйлдвэрийн хашаан доторх сул чөлөөт талбайг тарималжуулж нөхөн сэргээх зөвлөмж	Төслийн талбай	удаа	Цэцэрлэг- жүүлэлтийн төлөв- лөгөөнд тусгасан	**	**	2026 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай MNS 4585:2016
26		Төслийн үйл ажиллагааг илэрхийлсэн нэр хаяг бүхий самбар, ногоон байгууламж, явган хүний зам, талбай, тээврийн зогсоол зэрэг нь тэмдэг тэмдэглэгээтэй байна.	Төслийн талбай	Иж бүрэн	300.0	1	300.0	2026 он	
Дүн						300.0 мян.төгрөг			
Нийт дүн						8,800.0 мян.төг			

**Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн нутагт байрлах
“УБ транс” ХХК-ийн “Гаалийн хяналтын бүс” төслийн 2026 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөө**

4.3. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих төлөвлөгөө

Монгол улсын ерөнхийлөгч НҮБ-ийн ерөнхий Ассемблейн 76-р чуулган дээр байгаль орчны доройтол, цөлжилт, шар шороон шуургатай тэмцэх зорилгоор Монгол улс 2030 он нэхэд нэг тэрбум мод тарьж ургуулахаа зарласан. Мод тарьж ургуулах нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хөрсний биотопыг сэргээх, органик нэгдлийг хөрсөнд бий болгох зэрэг маш их ач холбогдолтой юм.

Гаалийн хяналтын бүсэд 962 м/кв талбайд ногоон байгууламж хийж гүйцэтгэсэн бөгөөд тордож хамгаалж услаж арчилна.


4.4. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Хүснэгт 13. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

д/д	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Талбайн хэмжээ /м ² /	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Зардал, төг		Хэрэгжүүлэх давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
						Нэгж мян.төг	Нийт мян.төг		
1.	Ногоон байгууламж бий болгох	Талбайн ргэн тойронд мод, бут, зүлэг тарьж модны арчлалт, хамгаалалтыг тогтмол хийсэн. Орчны 50 метр хүртэлх талбайг тогтмол хийх	Нэгж талбарын хүрээнд	Төслийн талбайн хэмжээнд	**	500.0	500.0	2026 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260 : 2011
Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний зардал							500.0 мян.төг		

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн нутагт байрлах
 “УБ транс” ХХК-ийн “Гаалийн хяналтын бүс” төслийн 2026 оны байгаль орчны
 менежментийн төлөвлөгөө

Зураг 8.1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 1000 ширхэг хайлаас тарих газрын байршил



**Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн нутагт байрлах
“УБ транс” ХХК-ийн “Гаалийн хяналтын бүс” төслийн 2026 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөө**

4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 14.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал,төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирж болзошгүй.	Хэрэв төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирэхэд төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой.	Төсөл хэрэгжүүлэх нийт талбайн хэмжээнд	-	-	Тухайн үед нь шийдэх	Үйл ажиллагааны турш	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014 оны 05 сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга/ , Бусад холбогдох салбарын яамнаас гаргасан дүрэм журмууд

4.6. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 15.Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Үе шат	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нэгж үнэ, төг	Нийт зардал төгрөг	Хэрэг-жүүлэгч	Хууль эрх зүйн шаардлага
1.	Үерийн аюул, хур тунадас	Зун, намрын улиралд үргэлжилсэн буюу их устай бороо орох, үйл ажиллагаа саатах	Үерийн далан хаалтын бүрэн бүтэн байдлыг хангах, засварлах, хог хаягдлыг цэвэрлэх	Төслийн талбайн хэмжээнд	**	**	**	Төслийн үйл ажиллагааны явцад	MNS 6010:2009 Гамшгийн холбогдолтой нэр томъёо, тодорхойлолт, ерөнхий анги
2.	Цахилгааны аюулгүй ажиллагаа	Үер, салхи шуурга, газар хөдлөлөөс цахилгаан тасрах, гэмтэх, осол үүсэх	Цахилгааны хэлбэлзэлтэй үед тэжээлээс автоматаар салгагддаг байх,	Төслийн талбайд	**	Дотоод зардал	**		MNS 4244:1994 “Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”
3.	Галын аюулгүй ажиллагаа	Талбайн тоног төхөөрөмжийн гэмтэл, шалбарсан утас, цахилгааны хэлбэлзэл,	Тоног төхөөрөмжийн гэмтлийг тухай бүр нь засах, цахилгааны утсыг шалгах, цахилгааны хүчдэл өөрчлөгдөх	Төслийн талбайд	**	Дотоод зардал	**		MNS 5390:2004

**Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн нутагт байрлах
“УБ транс” ХХК-ийн “Гаалийн хяналтын бүс” төслийн 2026 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөө**

		цахилгааны эх үүсвэрийн хүчдэл хэлбэлзэх	автоматоор тэжээлээс салгагддаг байх					Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS 4968: 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага MNS 4996:2000 Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавих ерөнхий шаардлага
		Гал гарахаас сэргийлэх	Галын хорын булан, галын хор байрлуулах ²	Баталгаат агуулах болон бусад газруудад	2	60.0	120.0	
5	Хөдөлмөр хамгаалал	Ажлын байрны хөдөлмөр, эрүүл ахуйн нөхцөлийг хангаагүйгээс ажиллагсадын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Хөдөлмөр хамгааллын нөхцөлийг хангах	Гаалийн хяналтын бүс төслийн нийт ажилчид	11	140000 Даатгал хөнгөлттэй	1,540,0	
6	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний зардал					1,660,0 мян.төг		

4.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 16. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	-Хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын цэгийг тохижуулах; -Хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж, тэмдэгжүүлсэн байна; -Хог хаягдлыг зориулалтын цэгээс нэгдсэн хогийн цэгт тээвэрлэхэд MNS 5344:2003, Ахуйн хог хаягдал тээвэрлэлт ангилал. Ерөнхий шаардлага” стандартыг баримтлах;	Хог хаягдлын цэг	Иж бүрэн	300.0	1	300.0	2026 он	БОАЖ-ын сайдын А/433 тогтоол Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, Хог хаягдлын тухай хууль
2	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, ангилан ялгасан хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт тушаах, хог хаягдлыг дахин ашиглах зэрэгт	Төслийн талбайд	Тогтмол	Үйл ажиллагааны зардал	**	**	2026 он	MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага

² Галын хорын үнийн саналыг “Сокол” ХХК-иас авав.

**Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн нутагт байрлах
“УБ транс” ХХК-ийн “Гаалийн хяналтын бүс” төслийн 2026 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөө**

	3R-ийн зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;							Засгийн газрын А/349 тогтоол Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт
5	Шингэн хог хаягдал хадгалах зориулалтын цэгтэй байх;	Шингэн хог хаягдлын	Тогтмол	Үйл ажиллагааны зардал	**	**	2026 он	БОАЖ, Сангийн сайдын 192, А/243 хамтарсан тушаал Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох
6	Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулах;	Төслийн талбайд	Тогтмол	Үйл ажиллагааны зардал	**	**	2026 он	
8	Үүсэх хог хаягдлын төрөл, кодыг ЗГ-ын 116 тогтоолд заасан хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтоосон байх; Хэрвээ аюултай хог хаягдлыг түр хадгалан мэргэжлийн байгууллагад хүргүүлэх;	Төслөөс үүсэх хог хаягдал	удаа	Үйл ажиллагааны зардал	**	**	2026 он	
9	Аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах;	Төслөөс үүсэх хог хаягдал	Удаа	Гэрээний үнийн дүнгээр	**	**	2026 он	
Нийт дүн					300,0 мян.төг			

4.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсч болзошгүй өөрчлөлтийг хянах, шинжлэх объект, байршил, баримтлах стандарт, арга аргачлал, хугацаа, хариуцах этгээд, хяналт шинжилгээний үр дүнг тайлагнах талаар тодорхой тусгана” хэмээн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдөр шинэчлэгдэн батлагдсан А/618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг удирдлага болгов. Үүний дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын явцад орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулав.

Тухайн төслийн хэрэгжүүлснээр үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ. Энэхүү орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн зардлыг гаргахдаа ЦУОШГ³-н харъяа БОХЗТЛ⁴-ийн үнийг үндэслэн зардлын тооцоог гаргав.

Хүснэгт 17.Хяналт мониторингийн цэгүүд

д/д	Орчны хяналт шинжилгээний цэг	Шинжилгээ хийх газрууд	Өргөрөг	Уртраг
1	Агаар орчны хяналт шинжилгээний цэг	Төслийн талбайд	46° 20' 36.32''	108° 21' 19.75''
2	Хөрсний хяналт шинжилгээний цэг	Хөрсний дээж авах 1-р цэг	46° 20' 34.65''	108° 21' 10.75''
3		Хөрсний дээж авах 2-р цэг	46° 20' 39.61''	108° 21' 24.00''
4	Газрын доорх усан орчны хяналт шинжилгээний цэг	Гүний худаг 1	46° 20' 34.85''	108° 21' 12.11''
		Гүний худаг 2	46° 20' 42.66''	108° 21' 27.11''

³ Ус Цаг Уур Орчны Хяналт Шинжилгээний Газар

⁴ Байгаль Орчны Хэмжил зүйн Төв Лаборатори

Зураг 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ус, хөрс, агаарын дээж авах байршлын зураг



Хүснэгт 18.Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн зардал

д/д	Хяналт үзүүлэлт	Байршил, цэгийн тоо	Давтамж	Хууль, бодлого, стандарт	Хариуцах эзэн	Хамтран хэрэгүүлэгч	Биелэлтийн шалгуур	Нэгж зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг
Хөрсөн бүрхэвч									
Хөрс бохирдох	Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд	1.Төслийн талбайд хог хаягдлын цэг -1 цэг. 46° 20' 32.50", 108° 21' 13.80"	Жилд 2 удаа	-	“УБ транс” ХХК	Говьсүмбэр Цаг уур орчны шинжилгээний газар	Шинжилгээний дүн	300,0	600,0
	Хүнд элементин шинжилгээ /8 элемент/	2. Гаалийн хяналтын талбайн гадна тээврийн хэрэгслийн зогсоолын орчимд – 1 цэг 46° 20' 31.05", 108° 21' 9.10"	Жилд 2 удаа	MNS 5850:2019	“УБ транс” ХХК		Шинжилгээний дүн	200,0	400,0
	Агаар тоос тоосонцорын хэмжээ тодорхойлох		Жилд нэг удаа		УБ транс” ХХК		Шинжилгээний дүн	100,0	100,0
Усан орчин бохирдох	Ерөнхий хими	- Гүний худгийн эх үүсвэрийн оролт дээр-1 -Бохир усны гаралт дээр -1	Жилд нэг удаа	1.Усны чанар эрүүл ахуйн стандарт MNS 900-2018	Төсөл хэрэг-жүүлэгч	Монгол Ус Төрийн Өмчит Үйлдвэрийн газар	Шинжилгээний дүн	75,0	75,0
	Хүнд элементийн шинжилгээ	/Бохирдуулагч бодис тус бүрээр/	Улирал бүр удаа	2. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019.09.27-ны өдрийн А/543 дугаар тушаал . “Ус бохирдуулах аюултай бодисын жагаалт” 3. Органик бодис \ Химийн хэрэгцээт хүчилтөрөгчийг тодорхойлох\			Шинжилгээний дүн		
Жилд зарцуулах зардал мян.төг		Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 сард багтаан БОУАӨЯ-нд тайлагнах нь зүйтэй						1,175,0 мян.төг	

4.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 19. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа хуваарь					Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			Он						
			2026	2027	2028	2029	2030		
2	Төслийн хүчин чадал энэхүү тайланд тусгагдсанаас өөр нэмэлт өөрчлөлт орох бүрд дахин байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний нэмэлт тодотгол хийлгэх шаардлагатай.	Тохиролцох						“УБ транс” ХХК	Байгаль орчны үнэлгээний тухай хуулийн 7.4, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам (Засгийн газрын 374 тогтоолын 2-р хавсралт)-ын 4.13- заалт
3	Төсөл хэрэгжих орон нутгийн удирдлагатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах.	10,000.0						“УБ транс” ХХК	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
4	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг БОУАӨЯ-нд хүргүүлж байх, тухайн жилийн БОМТ-г батлуулж байх	Үйл ажиллагааны зардал	Жил бүрийн 11 болон 12 сард					“УБ транс” ХХК	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.12-р заалт, БОАЖ-ын сайдын 2019 оны А/618 тоот тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
6	Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж мод тарих.	1,800.0						“УБ транс” ХХК	Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод үндэсний хөдөлгөөн
Нийт дүн		11,800.0							

4.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 20. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ, хэрэгжилтийг оролцогч талууд	БОМТ-ний тайлагнах хэлбэр	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Говьсүмбэр аймгийн байгаль орчны газарт	Тайлан	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан	Жил бүрийн 11 сарын 01-ны дотор	Үйл ажиллагааны зардал	Компани удирдлага, мэргэжилтнүүд	Нийслэлийн байгаль орчны газарт	
2	Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газарт	Төлөвлөгөө	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Жил бүрийн 12-р сард	Үйл ажиллагааны зардал	Компани удирдлага, мэргэжилтнүүд	Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газарт	
Нийт дүн						-		

Дүгнэлт:

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн нутагт хэрэгжиж буй “УБ транс” ХХК-ийн “Гаалийн хяналтын бүс” төслийн 2026 оны БОМТ-г БОАЖЯ-ны сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлан боловсруулсан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал нь **24,235,000 (Хорин дөрвөн сая хоёр зуун гучин таван мянган) төгрөг** төлөвлөлөө. Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох хууль, тогтоомж, стандарт, дүрэм журмын хүрээнд боловсруулагдсан энэхүү тайланд төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах, нөхөн сэргээлт, байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.